

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ОЮУТНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Монгол Коосэн” Технологийн коллежийн (цаашид “Сургууль” гэх) оюутны дүрмийн зорилго нь оюутныг хичээл сурлагадаа хариуцлагатай хандаж, бие даан сурах чадварыг хөгжүүлэх, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оюутны эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Оюутан нь шинжлэх ухааны мэдлэг, мэргэжлийн ур чадвартай, хууль шударга ёсыг дээдэлдэг, хүнлэг иргэн болохын төлөө хичээнгүйлэн суралцана.
- 1.3. Энэхүү дүрмийг тус сургуульд суралцаж байгаа оюутан бүр дагаж мөрдөнө.
- 1.4. Оюутны дүрмийг шинэчлэх, дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

Хоёр. Оюутны эрх, үүрэг

- 2.1. *Оюутан дараах эрхтэй:*
 - 2.1.1. Суралцах таатай орчин, нөхцөл бололцоогоор хангуулах;
 - 2.1.2. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу суралцах;
 - 2.1.3. Сургуулиас зохион байгуулж байгаа секц, сонгон, дугуйлан, клуб болон бусад үйл ажиллагаанд оролцох;
 - 2.1.4. Оюутан нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх тэмцээн, уралдаанд оролцох;
 - 2.1.5. Сургалтын төлбөр, хандивын зарцуулалтын талаар мэдээлэл авах;
 - 2.1.6. Сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гомдол гаргах, шаардлага тавих, мэдээлэл авах;
 - 2.1.7. Сургуулиас зарлах тэтгэлэг, хөнгөлөлтөд хамрагдах;
 - 2.1.8. Оюутан болон түүний эцэг эх, асран хамгаалагч хүсэлт гаргасан тохиолдолд жилийн чөлөө авах;
 - 2.1.9. Оюутан мэргэжлийнхээ дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр сонгох;
 - 2.1.10. Сургуулийн Удирдах зөвлөлд төлөөлөлтэй байх.
- 2.2. *Оюутан дараах үүрэгтэй:*
 - 2.2.1. Суралцах хугацаанд сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмших;
 - 2.2.2. Багш, ажилтны тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
 - 2.2.3. Бие дааж суралцах арга барилыг эзэмших;
 - 2.2.4. Багш, шавийн харилцааг хүндэтгэн дээдлэх;
 - 2.2.5. Сургуулийн Оюутны дүрэм, Оюутны ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх;
 - 2.2.6. Оюутан тус сургуулийн Сургалтын журам, сургалтын гэрээг дагаж мөрдөх;
 - 2.2.7. Хичээлийн цагийг баримтлан, үр бүтээлтэй ашиглах;
 - 2.2.8. Хичээлээс хоцрохгүй, хичээл таслахгүй байх;

- 2.2.9. Сургуулийн өмч хөрөнгө, эд хогшил, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлагыг ариг гамтай хэрэглэх;
- 2.2.10. Завсарлагаанаар хичээлд хоцорч орох, хичээлийн үеэр ангиас гарах, орох тохиолдолд хичээл зааж буй багшаас зөвшөөрөл авах;
- 2.2.11. Сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;
- 2.2.12. Дадлагын хичээлд суухдаа дадлагын хувцас өмсөж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахин, анхаарал болгоомжтой байх;
- 2.2.13. Сургуулийн орчинд улс төр, шашинтай холбоотой ухуулга, сурталчилгаа зохион байгуулахгүй байх;
- 2.2.14. Сургуулийн орчин болон олон нийтийн газар биеэ зөв боловсон авч явах, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахин биелүүлэх.
- 2.2.15. Олон нийтийн хэв журмыг зөрчихгүй байх, элдэв зөрчил, гэмт хэрэгт холбогдохгүй байх;
- 2.2.16. Оюутан цахим орчинд бусадтай зөв боловсон, хүндэтгэлтэй харьцаж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх;
- 2.2.17. Оюутан лаборатори, дадлагын газрыг хариуцсан багшийн зөвшөөрөлгүй ашиглахгүй байх.

Гурав. Оюутны сургууль болон олон нийтийн газар баримтлах дэг

3.1. Ерөнхий зүйл

- 3.1.1. Хариуцлагатай, сахилга баттай, үнэнч шударга байх;
- 3.1.2. Ахмад настан, эрдэмтэн багш, ажилтан, ажилчид, оюутан, найз нөхөд, зочид хэн бүхэнтэй мэндэлж, зөв боловсон харьцах;
- 3.1.3. Сургуулийн анги танхимд, коридорт биеэ зөв боловсон авч явах;
- 3.1.4. Сургуулийн болон олон нийтийн өмч хөрөнгөд ариг гамтай хандах;
- 3.1.5. Бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авахгүй байх;
- 3.1.6. Сургуульд үнэтэй эд зүйл авчрахгүй бөгөөд алдсан тохиолдолд сургууль хариуцахгүй;
- 3.1.7. Сургуулийн орчинд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй, бүх төрлийн тамхи татахгүй байх;
- 3.1.8. Биедээ шивээс, цоолбор /пирсинг/ хийхгүй байх;
- 3.1.9. Сургуулийн орчинд бусдыг дээрэлхэхгүй, гадуурхахгүй, хэрүүл маргаан хийхгүй, зодолдохгүй байх;
- 3.1.10. Сургууль дээр хонохгүй байх;
- 3.1.11. Бусдад төвөг учруулахгүй байх;
- 3.1.12. Дараах эд зүйлийг сургуульд авчрахыг хориглоно. Үүнд:
 - Согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, мансууруулах бодис
 - Шатамхай болон тэсэрч дэлбэрэх бодис
 - Хурц иртэй зүйл, хутга, зэвсэг
 - Гэрийн тэжээвэр амьтан

3.2. Анги, танхим, лаборатори, дадлагын газарт мөрдөх дэг

- 3.2.1. Хичээлийн бэлтгэлийг бүрэн хангаж ирэх;
- 3.2.2. Багштай босож мэндлэх;
- 3.2.3. Хичээл сургалтад санаачилгатай оролцох;
- 3.2.4. Ангид малгай, гадуур хувцастай суухгүй байх;
- 3.2.5. Дадлагын хичээлд дадлагын хувцас өмсөх;
- 3.2.6. Оюутан нь багшийн шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон цаг хугацаанд биелүүлж, багш шавийн харилцааг эрхэмлэх;
- 3.2.7. Анги, танхимд хичээлийн цагаар хүнсний зүйл хэрэглэхгүй байх;
- 3.2.8. Анги танхим, сургуулийн орчинд хог хаяхгүй байх;

- 3.2.9. Хичээлийн цагаар багшийн зөвшөөрөлгүй гар утас, таблет, чихэвч болон бусад цахим хэрэгслийг ашиглахгүй байх, хичээл эхлэхэд дууг нь хааж цүнхэндээ хийх (ашигласан тохиолдолд багш хураан авч, тухайн хичээлийн цаг дуусахад оюутанд буцаан өгөх);
- 3.2.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөх.

3.3. Цаг ашиглалт

- 3.3.1. Тухайн хичээлийн жилд оюутны хичээлийн ирц 75 хувиас доошгүй байна.
- 3.3.2. Оюутан хичээлээс чөлөө авах тохиолдолд Оюутны албанд хандаж чөлөөний хуудас авах ба Оюутны алба нь эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдсэний үндсэн дээр чөлөө олгоно. 7 өдрөөс дээш өдрийн чөлөөг Сургалтын алба олгоно.
- 3.3.3. Дараах тохиолдолд оюутанд чөлөө олгоно. Үүнд:
- 3.3.3.1 Оюутан өөрөө өвдөх (хичээлдээ хэвийн хамрагдаж эхлэх өдрөөс эхлээд 2 хоногийн дотор эмчийн магадлагааг эх хувиар нь авч ирэх, хэтэрсэн тохиолдолд тасалснаар авах);
(Энэхүү хэсэгт 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн Захирлын А/13 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан)
- 3.3.3.2 Оюутны аав, ээж, ах, эгч, дүү, эмээ, өвөө, асран хамгаалагч нас барсан тохиолдолд 5 өдөр хүртэлх чөлөөг олгоно (нас барсны гэрчилгээ авч ирэх);
- 3.3.3.3 Хөл хорионд орох (байгалийн давагдашгүй хүчин зүйл, гоц халдварт, халдварт өвчин);
- 3.3.3.4 Олон улсын болон улсын (нийслэл, аймаг, дүүргийн тэмцээн хамаарахгүй) чанартай уралдаан тэмцээнд оролцох (уралдаан, тэмцээний бэлтгэлийн хугацаа хамаарахгүй);
(Энэхүү хэсэгт 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн Захирлын А/13 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан)
- 3.3.3.5 Цэрэг татлагын үзлэгт хамрагдах үед (хөдөө орон нутгийн харьяалалтай бол 3 өдөр хүртэлх, хотын харьяалалтай бол 1 өдөр хүртэлх чөлөөг олгоно);
(Энэхүү хэсэгт 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн Захирлын А/13 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан)
- 3.3.3.6 Гадаад хэлний түвшин тогтоох шалгалт өгөх үед 1 өдөр хүртэлх чөлөөг олгоно (TOEIC, TOEFL, IELTS, JLPT хамаарна);
- 3.3.3.7 Виз мэдүүлэх тохиолдолд 1 өдөр хүртэлх чөлөөг олгоно;
- 3.3.3.8 Шүүх, цагдаагийн байгууллагад очих тохиолдолд 1 өдөр хүртэлх чөлөөг олгоно;
(Энэхүү хэсэгт 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн Захирлын А/13 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан)
- 3.3.3.9 Сургууль болон сургуультай хамтын ажиллагаатай байгууллагын үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцох.
- 3.3.4. Бусад тохиолдолд чөлөө олгохгүй.
(Энэхүү хэсэгт 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн Захирлын А/13 тоот тушаалаар нэмэлт оруулсан)
- 3.3.5. Оюутан чөлөөний хуудас бөглөсөн боловч чөлөө авсан шалтгаанаа баримтжуулаагүй тохиолдолд тасалсанд тооцно.
- 3.3.6. Чөлөөг нөхөж олгохгүй.
- 3.3.7. Хичээл эхлэхээс өмнө ирж, хичээлийн бэлтгэлээ хангана.
- 3.3.8. Хичээлийн бус цагаар сургууль дээр зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох оюутан Оюутны албанд бичгээр хүсэлт гаргаж зөвшөөрөл авна.
- 3.3.9. Хичээлээс хоцорсон тохиолдолд хоцорсон цагаа жижүүр багшид тэмдэглүүлэн, хичээлд сууна.

- 3.3.10. Хичээлд 20 минутаас дээш хугацаагаар хоцорч ирсэн оюутныг хичээлд суулгах боловч тухайн хичээлийг тасалсанд тооцно.
- 3.3.11. 20 минут хүртэлх 3 удаагийн хоцролтыг хичээлийн 2 цаг /80 минут/ тасалсанд тооцно.
(Энэхүү хэсэгт 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн Захирлын А/13 тоот тушаалаар нэмэлт оруулсан)
- 3.4. Шүүгээний хэрэглээ
- 3.4.1. Чийгтэй, нойтон хувцас орхихгүй байх;
- 3.4.2. Хүнсний болон шингэн зүйл орхихгүй байх;
- 3.4.3. Эмх цэгцтэй, хаягтай байх;
- 3.4.4. Өөрийн буруугаас түлхүүр гэж, цоож эвдсэн тохиолдолд төлбөрийг тухайн оюутан хариуцаж төлнө;
- 3.4.5. Хичээлийн жил дуусах болон сургуулиас чөлөөлөгдөх үед шүүгээний түлхүүрийг Оюутны албанд хүлээлгэн өгнө;
- 3.4.6. Шүүгээнд гар утас, бэлэн мөнгө, төлбөрийн карт, түрийвч, үнэтэй эд зүйлийг хийхгүй биедээ авч явна.
- 3.5. Дараах тохиолдолд оюутанд жилийн чөлөө олгоно. Үүнд:
- 3.5.1.1. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цаашид үргэлжлүүлэн суралцах боломжгүй болсон оюутан нэг хүртэлх жилийн хугацаатай чөлөө авч болно. Үүнд:
а/ Өвчтэй учир
б/ Хүүхэд төрүүлэх
в/ Ар гэрийн гачигдал
г/ Төлбөрийн чадваргүй байдал
д/ Цэргийн алба хаах
е/ Бусад
- 3.5.1.2. Оюутан нь тухайн хичээлийн жилд хүндэтгэн үзэх шалтгаанаар 1 сараас дээш хугацаагаар чөлөө авах тохиолдолд жилийн чөлөө олгоно.
- 3.5.1.3. Хоёр улирлын турш сургалтын төлбөр төлөөгүй тохиолдолд жилийн чөлөө олгоно.
- 3.5.1.4. Жилийн чөлөөг дараах тохиолдолд нэг удаа сунгана. Үүнд:
а/ Чөлөөтэй байх үедээ хүүхэд төрүүлсэн
б/ Эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр удаан хугацаагаар эмчлүүлэх
в/ Ар гэрийн гачигдал
д/ Чөлөөтэй хугацаандаа цэргийн албанд татагдсан

Дөрөв. Сургалтын төлбөрийн талаар

- 4.1. Оюутан өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тохиолдолд сургалтын төлбөрийн зөрүүг буцаан олгоно.
- 4.2. Хангалтгүй суралцсан, мөн сахилгын зөрчлийн улмаас сургуулиас чөлөөлөгдсөн, хүндэтгэх шалтгаангүйгээр сургуулийг орхисон тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.
- 4.3. Оюутан сургалтын төлбөрийг сургалтын гэрээнд заасан хугацаанд төлнө.
- 4.4. Сургалтын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, хугацаа хэтэрсэн тохиолдолд алданги тооцно.
- 4.5. Өөр сургуулиас шилжиж ирсэн оюутан суралцсан хичээлийн кредитийг тооцуулан сургалтын төлбөр төлнө.
- 4.6. Сургалтын төлбөрийн үлдэгдэлтэй оюутанд лавлагаа, тодорхойлолт олгохгүй.

Тав. Хүлээх хариуцлага

5.1. Дараах зөрчил гаргасан тохиолдолд сануулах, улируулан суралцуулах, шаардлагатай тохиолдолд сургуулиас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

5.1.1. *Дараах тохиолдолд сануулах хуудас өгнө. Үүнд:*

- 5.1.1.1. Хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг санаатайгаар үймүүлж, тасалдуулах;
- 5.1.1.2. Багш, ажилтан, оюутан, эцэг эхтэй хүндэтгэлгүй харьцах;
- 5.1.1.3. Оюутан мөрийтэй болон бооцоот тоглоом тоглох;
- 5.1.1.4. Бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авах;
- 5.1.1.5. Сургуулийн орчинд бүх төрлийн тамхи хэрэглэх;
- 5.1.1.6. Хичээл дундуур гар утас, цахим төхөөрөмжийг ашиглаж, багшийн шаардлагыг биелүүлээгүй;
- 5.1.1.7. Хэрүүл маргаан өдөөх, бусдыг дээрэлхэх, доромжлох;
- 5.1.1.8. Сургуульд дээр дүрмийн 3.1.12 дахь хэсэгт заасан зүйлсийг авчрах;
- 5.1.1.9. Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах хугацаанд сургуулийн болон эх орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаанд оролцох, үйлдэл гаргах;
- 5.1.1.10. Анги, танхимд хичээлийн бус цагаар гар утас, компьютероор тоглоом тоглох

5.1.2. Сануулах хуудас нь авсан өдрөөсөө хойш 90 хоногийн хугацаатай байна. Энэхүү хугацаанд өвлийн болон зуны амралтын хугацаа хамаарахгүй.
(Энэхүү хэсэгт 2024 оны 11-р сарын 15-ны өдрийн Захирлын А/17 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан)

5.1.3. Тус сургуулийн “Сургалтын журам”-ын 4.4.10, 4.4.11, 4.6.8.1 дэхь хэсэгт заасны дагуу курс улируулан суралцуулна.

5.1.4. Оюутны ирц тухайн хичээлийн жилд 75 хувиас доошгүй байна. Оюутны ирц 75 хувьд хүрээгүй бол улируулан суралцуулна.

5.1.5. *Дараах тохиолдолд сургуулиас чөлөөлөх арга хэмжээ авна. Үүнд:*

- 5.1.5.1. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх;
- 5.1.5.2. Гэмт хэрэгт холбогдох, хулгай дээрэм, зодоон зохион байгуулах, оролцох;
- 5.1.5.3. Энэ дүрмийн 5.1.1 дэх хэсэгт заасан зөрчлийг давтан гаргаж, 3 удаа сануулах хуудас бичгээр авсан бол;
- 5.1.5.4. Тус сургуулийн “Сургалтын журам”-ын 4.5.4 дэх хэсэгт заасны дагуу сургуулиас чөлөөлнө.

5.1.6. *Зөрчил гаргасан оюутанд хүлээлгэх бусад арга хэмжээ*

- 5.1.6.1. Оюутны тэтгэлэгт хөтөлбөр, оюутан солилцооны болон бусад хөтөлбөр, гадаад улсад болон дотоодод хийх үйлдвэрлэлийн дадлага, бусад уралдаан, тэмцээнд оролцохыг хориглоно;
- 5.1.6.2. Сургуульд тустай ажил хийлгэх;
- 5.1.6.3. Учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх.

- 5.2. Оюутны зөрчлийн асуудлыг сургуулийн Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гаргасан санал, дүгнэлтэд үндэслэн Сургуулийн Хөдөлмөрийн дотоод журам, Оюутны дүрмийн 5-р зүйл, Оюутны ёс зүйн дүрмийн 4-р зүйлийн дагуу шийдвэр гаргах ба эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтан, оюутанд тус тус мэдэгдэнэ.
- 5.3. Сургуулийн Хөдөлмөрийн дотоод журам, Сургалтын журам, Оюутны дүрэм, Оюутны ёс зүйн дүрмийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй зөрчлийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

-00о00-

Уншиж танилцсан оюутны овог, нэр: _____

Оюутны анги: _____

Оюутны гарын үсэг: _____

..... оны-р сарын-ны өдөр

Оюутанд чөлөө олгох маягт

"Монгол Коосэн" Технологийн коллежийн оюутны албанд		
Чөлөө хүсэх тухай		
Оюутны мэдээлэл	Асран хамгаалагчийн мэдээлэл	
Анги:	Оюутны хэн болох:	
Овог :	Асран хамгаалагчийн нэр:	
Нэр :	Асран хамгаалагчийн утасны дугаар:	
Утасны дугаар:	утас 1:	
	утас 2:	
Хугацаа өдрийн чөлөө цагийн чөлөө
	20 оны -р сарын -ны өдрөөс	20 оны -р сарын -ны өдрийн
	20 оны -р сарын -ны өдөр хүртэл : цагаас
	 : цаг хүртэл
Чөлөө авч буй шалтгаан		
Оюутны албаны тэмдэглэгээ		
	Анги удирдсан багшийн гарын үсэг:	
	Оюутны албаны ажилтны гарын үсэг:	

“Монгол Коосэн” Технологийн коллежийн
“Оюутны дүрэм”-ийн хавсралт 2

"МОНГОЛ КООСЭН" ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТНЫ САНУУЛАХ ХУУДАС						
Оюутны овог:						
Оюутны нэр:						
Оюутны анги:						
Харьяа тэнхим:						
Ангийн зөвлөх багш:						
Зөрчил гаргасан удаа	Гаргасан зөрчил	Үндэслэсэн дүрэм, журам	Он сар өдөр	Сануулга хүлээн авсан оюутан	Сануулга өгсөн ажилтан	Ангийн багш
1						
2						
3						
Тэмдэглэл, шийдвэр						
Оюутны албаны менежер: / гарын үсэг /						